



ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ  
ДАРГА Д.ЦОГТБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-06-17 № 133

Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Тавантолгой ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2011 оны 143 дугаар тушаалыг үндэслэн тус байгууллагаас Төрийн өмчийн хороонд хоёр ширхэг iPad, хоёр ширхэг iPhone-4 гар утсыг шилжүүлэн өгсөн байна. Төрийн өмчийн хороо нийт 2,830,000 төгрөгийн үнэ бүхий дээрх хөрөнгийг данс бүртгэлд тусгалгүйгээр 2011 оны шинэ жилээр сугалааны шагналд зарцуулжээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.

1. Хууль зөрчсөн дээрх үйлдлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах;
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2013 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Д.Цогтбаатар, ТӨХ-ны Тамгын газрын захирал Ц.Одмаа, Эрдэнэс Тавантолгой ХХК-ийн гүйцэтгэх захирал Я.Батсуурь нарт даалгаж байна.

АУДИТОР

Ж.ЯДМАА

УХА0122

070357